



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 403

Улаанбаатар хот

### Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.3 дахь хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Э.Тамиртай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 8.2.а. дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал Эрдэнэбилэгийн Тамиртай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан тул үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

